



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 04

Чингис хот

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх  
төлөвлөгөөт арга хэмжээг зохион  
байгуулах тухай

Засгийн газрын “Журам, чиглэл батлах тухай” 43 дугаар тогтоолыг үндэслэн  
ДААЛГАХ нь:

Мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, тархалтыг бууруулах, тэмцэх, отор нүүдэл, өвөлжилтийн хүндрэл, өвчний улмаас хорогдсон малын сэг зэм болон урьдчилан сэргийлэх зорилгоор малын бэлчээр, бууц, хашаа байр, уст цэг, усны эх булгийг халдваргүйтгэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах, “Журам, чиглэл батлах тухай” Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах зорилгоор сумын Засаг дарга нар, Мал эмнэлгийн газар, Мал эмнэлгийн тасаг, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт тус тус даалгасугай.

Нэг. Сумын Засаг дарга нарт:

1.1. Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ захирамжаар ажлын хэсэг томилж зохион байгуулах төлөвлөгөө гарган төв зам дагуу болон бусад газарт хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж, булж устгах, бэлчээр, өтөг бууц, өвөлжөө, хаваржаа, малын хашаа, хороо, худаг уст цэг, гол горхи, булаг, шандны эхийг халдваргүйтгэх ажлыг мэргэжлийн байгууллагын зөвлөмж, стандартын хүрээнд зохион байгуулах;

1.2. Мал, амьтны сэг зэмийг устгах, халдваргүйтгэх ажлыг холбогдох хууль эрх зүйн хүрээнд шаардагдах хүн хүч, тээврийн хэрэгсэл, шатах тослох материал, болон бусад зардлыг шийдвэрлэж уг ажилд орон нутгийн байгууллага, малчдыг өргөнөөр оролцуулах, мөн олон нийтийн санал, санаачилгыг өрнүүлэн, энэ ажлын зорилго ач холбогдлыг өргөн сурталчлах;

1.3. Отроор ирсэн малчин өрхийг буцаж нүүхээс өмнө Засгийн газрын 43 дугаар тогтоолоор батлагдсан “ Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журам”-д заасны дагуу малчидтай хамтран сэг, зэм устгалын ажлыг зохион байгуулах;

1.4. Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газраас гаргасан Мал эмнэлгийн ажил, үйлчилгээ явуулах зөвлөмж зэргийг үндэслэн тухайн харьяалах нутаг дэвсгэрт отор нүүдэл хийх, дамжин өнгөрөх чиглэл, хугацаа, нутаг дэвсгэрийг тогтоож, хяналт тавьж ажиллах;

1.5. Мал амьтны гоц халдварт өвчин гарсан тохиолдолд сумын ЗДТГ, төрийн байгууллага, хувийн аж ахуйн нэгж хоорондын уялдаа холбоог сайжруулах, гамшгаас хамгаалах мэргэжлийн баг, мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг хангах;

## 2.

### Хоёр. Мал эмнэлгийн газар, Мал эмнэлгийн тасагт:

2.1. Аймаг, сумын хэмжээнд халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх нэгдсэн төлөвлөгөө гарган төв, орон нутгийн байгууллагуудад хүргүүлж, мэргэжлийн нэгдсэн заавар, удирдамжаар ханган, хэрэгжилтэд хяналт тавьж зохион байгуулж ажиллах;

2.2. Мал, амьтны шимэгчтэх, халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардлагатай вакцин, оношлуурыг технологит хугацаанд нь хүргүүлж, хэрэгжилтийг аймаг, сумын хэмжээнд 2023 оны 03 дугаар сарын 15-наас 11 дүгээр сарын 01-ний хүртэл хийж, гүйцэтгэн 2023 оны 11 дүгээр сарын 15-ны дотор эцсийн дүнг өгөх;

2.3. Монгол улсын малын эмийн бүртгэлд орсон, чанар стандартын шаардлага хангасан, хүн, малын эрүүл мэнд, байгаль экологид хор нөлөөгүй, халдваргүйтгэлийн бодис, бэлдмэлийн нөөцийг аймаг, сумын хэмжээнд бүрдүүлэн, хангамжийг сайжруулж ажиллах;

2.4. Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд, түүхий эд бүтээгдэхүүн хадгалдаг

зоорь, агуулахууд, хүнсний зах, худалдааны төвүүд, гахай, шувуу, амьтан тэжээдэг аж ахуйн нэгжүүдтэй халдваргүйтгэл хийх гэрээ байгуулан хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.5. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн дагуу мал, амьтан өмчлөгч этгээдийн үүрэг, хариуцлагыг тодорхойлсон зөвлөмж гарган хүргүүлэх ажлыг зохион байгуулах;

2.6. Орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх ажлыг зохион байгуулахад төрийн болон хувийн хэвшлийн мал эмнэлгийн мэргэжлийн байгууллага болон бусад мэргэжлийн байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж, хамтран ажиллах;

2.7. Төв суурин газар, улс, аймгийн чанартай зам, малын бэлчээр, тариалангийн талбай, гол, горхи, булаг шандны орчимд мал, амьтны хүүр, сэг зэмийг орхиж хаясан эх үүсвэрийг мөрдөн мөшгөж тогтоон, буруутай этгээдэд холбогдох хууль, журмын дагуу хариуцлага тооцох;

2.8. Мал, амьтны хүүр, сэг зэмийг устгах, халдваргүйтгэхэд тавих ерөнхий шаардлага MMS 6406:2013 стандартыг мөрдүүлэн суманд үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгж тус бүрд хариуцан ажиллах газар, орчныг хуваарилан өгч албажуулан, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн ажлыг малчин, мал бүхий иргэдийг татан оролцуулж хийлгүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

2.9. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр үхсэн мал, амьтны хүүр, сэг зэм устгал, халдваргүйтгэлийн ач холбогдлын талаарх мэдээлэл сурталчилгааг олон нийтэд тодорхой төлөвлөгөө, давтамжтайгаар дамжуулах, халдваргүйтгэлийн ажлын талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

2.10. Отроор ирсэн малчин өрх нүүдэллэн буцах үед мал сүрэгт толгой дараалан үзлэг хийн, зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг булж устган, халдваргүйтгэл хийлгэснийг үндэслэн мал эмнэлгийн гэрчилгээ олгох;

3.

Гурав. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт:

Сумын Засаг даргын захирамж, ажлын төлөвлөгөө гаргуулан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах;


3.1.Хээлтүүлэгч малын суурьт гоц халдварт, халдварт өвчний эмнэлзүйн үзлэгийг сумын мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээр хийлгэх, шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээнд хамруулж баталгаа гаргуулах ажлыг хамтран зохион байгуулах;

3.2.Аймаг ,бүс дамжуулан хээлтүүлэгч мал тээвэрлэх, худалдаалах, нийлүүлэх ажилд хяналт тавих,

Дөрөв. Биелэлтийг тайлагнах:

4.1 Сумын хэмжээнд үхсэн мал, амьтны сэг,зэмийг устгах, халдваргүйтгэх ажлыг зохион байгуулж, холбогдох дүн, мэдээ, тайланг 2023 оны 6 дугаар сарын 10-ны дотор Мал эмнэлгийн газарт ирүүлэн, Мал эмнэлгийн газар нь дүнг аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст танилцуулж, Мал эмнэлгийн Ерөнхий газарт хүргүүлэх.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ